



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/35

Булган сум

Монгол Улсад орчин цагийн
Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны
105 жилийн ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10 дахь заалт, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2026 онд хэрэгжүүлэх гэрээний 1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 105 жилийн ойг тусгай төлөвлөгөө гаргаж, шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 105 жилийг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит “Марш, тусгай бэлтгэл”-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Т.Нямхүү), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 439 дүгээр хаалттай хорих ангийн захирагч (дэд хурандаа Б.Наранбат)-д хариуцуулсугай.

3. Тэмцээнүүдийн шагналын зардал 9,740,000 (есөн сая долоон зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хавсралтын дагуу зарцуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.П.РЭВ-ОЧИР



6326010174

Аймгийн Засаг даргын 2025 оны
 02 дугаар сарын 16 -ны/ний өдрийн
 А/135 дугаар захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Бүгд
1	“Марш, тусгай бэлтгэл”-ийн аварга шалгаруулах тэмцээний зардал	5,740,000	1-р байр 1,000,000 2-р байр 800,000 3-р байр 600,000 Өргөмжлөл 5*100,000=500,000 Медаль 33ш*20,000=660,000 Буудлагын тэмцээний медаль 9*20,000=180,000 Айраг-200л*10,000=2,000,000
2	Зэвсэгт хүчний 105 жилийн ойн нэрэмжит насанд хүрэгчид, өсвөр үеийн аварга шалгаруулах хийн буудлагын тэмцээний зардал	1,300,000	1-р Байр 4*50,000=200,000 2-р Байр 4*40,000=160,000 3-р Байр 4*30,000=120,000 Медаль 12ш*20,000=240,000 Шүүгч 2хүн 40,000=80,000 Сум 2 хайрцаг 500,000 Нийт – 1,060,000
3	Монгол улсад хурандаа цол үүссэний 90 жилийн ойг тохиолдуулан Булган аймагт ажиллаж амьдарч байгаад бэлтгэл, чөлөөнд гарсан “Хурандаа” нарт хүндэтгэл үзүүлэх	2,700,000	Гарын бэлэг хүн 15ш*50,000=750,000 Хүндэтгэлийн зоог, 15хүн*50,000төг=750,000 Айраг-120л*10,000=1,200,000